

Эцэст нь дүгнэхэд энэхүү илтгэлд цагдаагийн байгууллагаас нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох тусгай ажиллагааны төлөвлөлтийн талаар авч үзсэн хэдий ч төрийн байгууллага, нэн ялангуяа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн нэгдсэн төлөвлөлтийг боловсруулах хэрэгцээ шаардлага одоо зүй ёсоор тавигдаж байгаад анхаарал хандуулах болсныг сануулж байна.

Мөн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг зохицуулах үүрэг бүхий субъектүүд дотроос иргэдтэй хамгийн ойр, тэдний дэргэд буюу хэрэг явдлын голомт дээр цагдаагийн байгууллага, түүний алба хаагчид ажилладаг бөгөөд ямар ч тохиолдолд хүч хэрэглэхээс зайлсхийх шаардлага тавигддаг бөгөөд төлөвлөлтийг энэхүү шаардлагад аль болохуйц нийцүүлэх нь чухал гэдэг нь тодорхой юм.

Үүний эцсийн үр дүн иргэдийн эрх, эрх чөлөөг бодитоор эдлүүлэх, тухайлбал нийгэм, улс төр, эдийн засгийн болон бусад чиглэлээр жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ хуулийн хүрээнд эдлэх нөхцлийг бүрдүүлэхэд оршиж байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч.
цагдаагийн хошууч Н.Мөнх-Итгэл*

ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Дэлхийн улс орнууд даяаршлын үйл явцад эрчимтэй шилжиж байгаа нь хүн төрөлхтний нийтлэг эрх ашгийн нэг томоохон дэвшил боловч, үүнийг дагасан сөрөг үр дагавар ихээр үүсэн бий болсоор байна.

Аюулгүй байдлын уламжлалт ойлголт хүрээгээ тэлж терроризм, халдварт өвчний тархалт, экологийн сүйрэл, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол болон зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис, хүн худалдаалах гэх мэт үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг улам өсөн нэмэгдсээр байна. Дээрхи гэмт хэрэг, хууль бус үйлдэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн үед таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах нь дэлхийн улс орнууд төдийгүй манай улсын хэмжээнд тулгамдсан томоохон асуудлын нэг юм.

Сүүлийн жилүүдэд “терроризм¹” гэх дэлхий нийтийг айдаст автуулсан шинэ нэр томъёо ихээр сонсогдох боллоо. Терроризм гэж “нийгмийн эсхүл

¹ Терроризмтой тэмцэх тухай Монгол Улсын хууль. 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Их хурлаас баталсан. “3.1.1. дэх хэсэг. "терроризм" гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн

түүний тодорхой хэсгийг айдаст автуулах зорилго бүхий сэтгэл зүйн дайралт юм¹” гэжээ. Олон улсын терроризмд гадаад орнуудын төр, засгийн болон дипломат төлөөлөгчийн газар, элчин сайдын яамд, олон улсын байгууллагын байранд хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, хүмүүс олноор цугласан урлаг, спортын газар болон худалдаа үйлчилгээний томоохон газруудад, нисэх онгоцны буудал, галт тэрэгний өртөө, буудлыг дэлбэлэх, агаарын хөлгийг барьцаалах зэрэг арга түгээмэл хэрэглэгдэж байна.

Хулгайч хүн дэл сул бүх юмыг “туучихдаг” бол террористууд боломжтой бүхэн рүү довтолдог. Терроризм гэхээр л зөвхөн гадаад оронд болдог, гадны террорист бүлэглэл үйл ажиллагаа явуулдаг төдийгөөр ойлгож болохгүй бөгөөд энэ ажиллагаа манай улсад ч үйлдэгдэхийг үгүйсгэх аргагүй.

Террорист үйлдэлтэй адил үйлдэл манай улсад гарч байсан. Тухайлбал: 2008 оны 06 дугаар сард Дорнод аймгийн Чойбалсан хотын цэвэр усны байгууламжид химийн хорт бодис хийхийг завдсан, 2013 оны 09 дүгээр сард “Гал үндэстэн холбоо”-ны тэргүүн Мөнхбаяр нар төрийн ордны орчмын барилгад тэсрэх бөмбөг байрлуулж, төрийн тусгай хамгаалалттай газрын хашаанд байлдааны гранат, галт зэвсэг авч очиж улмаар галт зэвсгээр буудсан зэрэг үйлдлийг дурьдаж болох юм. Хэрэв эдгээр үйлдэл нь зорилгодоо хүрч, төгс үйлдэгдсэн бол ямар их хор хохирол учирч болохыг төсөөлөх аргагүй.

Манай улс хил залгаа хоёр их гүрэн болох ОХУ, БНХАУ-тай харилцан визгүй зорчиж байгаа нь нэг талаараа таатай асуудал боловч нөгөө талаар сөрөг үр дагавар үүсгэхийг үгүйсгэх аргагүй билээ. Талибаны² эгнээнд террорист ажиллагаанд сургагдсан БНХАУ-ын хэдэн зуун мусульман шашинтай уйгар иргэн байдгийг хятадын албаны хүмүүс тэмдэглэжээ³. Манай улс БНХАУ-ын ШУӨЗО-той 1000 гаруй км газар нутгаар хиллэдэг байна. Австралийн “Глобал терроризм индекс” байгууллагын явуулсан судалгаагаар ОХУ терроризмын аюул өндөр орнуудын есдүгээр байрт бичигдсэн байна⁴.

тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагаа” гэж томъёолжээ. Цахим эх сурвалж, холбоо: <http://www.legalinfo.mn/law/details/476>

¹ Терроризмын эсрэг Монголын холбоо, Аюулгүй байдал, хамгаалалтын академи. Терроризм, аюулгүй байдал. - УБ., 2012.

² 1979 онд Афганистан Улсад байгуулагдсан алан хядах ажиллагаа явуулдаг, олон улсад аюултай, дэлхийд зартай, мусульман шашинтай террорист байгууллагын жагсаалтад орсот Талибан гэдэг нь “шашны сурагч” гэсэн утгатай.

³ Терроризмын эсрэг Монголын холбоо, Аюулгүй байдал, хамгаалалтын академи. Терроризм, аюулгүй байдал. - УБ., 2012.

⁴ Цахим эх сурвалж, холбоо: <http://nctc.gov.mn/index.php>

Монгол Улс 1990-ээд оноос эхлэн ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж, 1992 онд шинэ Үндсэн хууль¹, 1994 онд Үндэсний аюулгүй байдлын анхны үзэл баримтлал². 2001 онд Үндэсний аюулгүй байдлын тухай хууль³ тус тус батлагдан гарсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1.2. дах хэсэгт "Монгол Улсын иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ...хамгаалуулах эрхтэй", 19 дүгээр зүйлийн 1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна", мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1. дэх хэсэг Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 1.1.1. дэх хэсэгт "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ", мөн 1.1.5. дах хэсэгт "Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна" гэж тус тус заасан нь төрөөс олон нийтийн аюулгүй байдлыг хангах бодлогын эрх зүйн орчныг бүрдүүлж өгч байгаа хэлбэр юм.

Тэгвэл Цагдаагийн албаны тухай хуульд заасан олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиг үүрэг бол террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх⁴ үйл ажиллагааны эхлэл төдийгүй нэг хэлбэр юм.

Улсын Их Хурлын 2012 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Шинэчлэлийн Засгийн газар Улсын Их Хурлын 2012 оны 09 сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор "Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг баталсан. Уг хөтөлбөрийн дагуу салбар бүрт шинэчлэл хийгдэж, Хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд "Цагдаагийн албаны тухай хууль⁵"-ийг шинэчлэн баталж, 2014 оны нэгдүгээр сарын 1-ны өдрөөс мөрдөж эхэлсэн. Энэ хуулиар "Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага мөн⁶" гэж цагдаагийн албаны статусыг томъёолсон байдаг.

¹ Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд батлагдсан. Цахим эх сурвалж, холбоос: www.legelinfo.mn

² Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Цахим эх сурвалж: www.legelinfo.mn

³ Үндэсний аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль. Цахим эх сурвалж, холбоос: www.legelinfo.mn

⁴ Терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.10. дах хэсэгт заасныг ойлгоно.

⁵ Цагдаагийн албаны тухай Монгол Улсын хууль. Цахим эх сурвалж, холбоос: www.legelinfo.mn

⁶ Мөн хуулийн 3 дугаар зүйл.

Цагдаагийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болж, урьд өмнө улс орны дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүргийг гүйцэтгэж байсан Дотоодын цэргийн чиг үүргүүд Цагдаагийн байгууллагын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд шилжсэн билээ.

Дэлхийн 40 орчим улс орнуудын дотоод аюулгүй байдлаа хангах чиг үүрэгтэй байгууллагуудын талаар судалгаа хийхэд эдгээр байгууллагууд нь Хууль зүйн болон Дотоод хэргийн яамандаа харъяалагддаг, цэргийн статустай хууль сахиулах байгууллагууд бөгөөд улсын дотоод аюулгүй байдлыг хамгаалах, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, кибер аюулгүй байдалтай тэмцэх, улсын онц чухал объект, байгууламжийг хамгаалах, нийтийн эмх замбараагүй байдал бий болсон үед хэв журам сахиулах, байгалийн гамшиг, гэнэтийн аюул тохиолдсон үед ард иргэдийг авран хамгаалах, гадаадын элчин сайдын яам, консул, дипломат төлөөлөгчийн газар, өндөр хэмжээний зочин төлөөлөгчийн аюулгүй байдлыг хангах, улсын хилийн хамгаалалт болон хилийн шалган нэвтрүүлэх ажиллагааг хариуцах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх зэрэг үүргийг гүйцэтгэдэг байна.

Манай улсын хувьд олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэдэг нэр томъёо шинээр хэрэглэгдэж байгаа бөгөөд үүнд чухам юуг хамааруулан ойлгох талаар албан ёсны хуульчилсан тайлбар гараагүй байна.

Улсын онц чухал объект болон бусад объект, дипломат төлөөлөгчийн газрыг хамгаалах, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэмийг сахиулах, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах зэрэг Цагдаагийн албаны тухай хуулинд заасан чиг үүргийг олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа гэж ойлгохоор байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь олон улсад **“public security”** буюу хамгаалах, **“public safety”** аюулгүй байдлыг хангах гэсэн чиг үүргээр хэрэгждэг.

“public security” гэдэг чиг үүрэгт дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал болон бусад объектыг хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх зэрэг хамгаалах чиг үүрэг багтдаг.

“public safety” гэдэг чиг үүрэгт байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул, эмх замбараагүй байдал, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах, жагсаал цуглааныг албадан тараах зэрэг нийтийн аюулгүй байдалд аюул учруулах байгалийн болон хүний хүчин зүйлээс хамаарсан аливаа

үйл явдлаас урьдчилан сэргийлэх, аврах, хамгаалах иргэнд үйлчилгээ үзүүлэх, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг багтдаг байна.

АНУ-д “олон нийтийн аюулгүй байдал нь иргэд, байгууллагын сайн сайхны төлөөх аюулын эсрэг үйл ажиллагаа ба тэдний эрхийг хамгаалдаг Засгийн газрын үйл ажиллагаа юм” гэж үздэг ажээ¹.

Манай улсад одоогоор хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, цагдаагийн хурандаа Ж.Долгорсүрэн “нийтийн аюулгүй байдал гэдэг нь байгалийн гамшиг, нийтэд хамааралтай бусад аюул осол болон зарим байгууллага, хүмүүс хүрээлэн байгаа орчиндоо эд зүйл, механизмтай зүй бус харьцсанаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд учирч болох хор хөнөөлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьчилан сэргийлэх зорилготой, иргэний нийгмийн бүтээн байгуулалтын хэрэгцээт шаардлагаар нөхцөлдөн гарсан, монголын ард түмний ашиг сонирхолд нийцсэн эрх зүй, зохион байгуулалт-техникийн хэм хэмжээ, горимоор зохицуулагдаж байгаа нийгмийн харилцааны тогтолцоо юм²” гэж тодорхойлсон байна.

Тэгвэл Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, доктор, профессор С.Нарангэрэл “Тухайн улсад улс төрийн, эдийн засгийн ба нийгэмшлийн тогтворгүй байдлыг тогтоон хангах, хуулиудыг чанд сахин биелүүлэх ба эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төрийн, эдийн засгийн, нийгэмлийн, цэргийн, экологийн, мэдээллийн ба бусад шинжтэй дотоод ба гадаад шинж чанартай аюул заналхийллээс бие хүн, нийгэм ба төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал³” гэж онолын хувьд тодорхойлжээ.

Үндэсний аюулгүй байдлыг хангах олон улсын практикт жижиг, буурай улсын үндэсний аюулгүй байдлын тэргүүн зэрэгт *дотоод аюулгүй байдлын асуудал* тавигддаг байна⁴. Тодруулбал: гадны том гүрнүүдийн зүгээс жижиг, буурай улсуудад чиглэсэн бодлого хэрэгжүүлэхдээ дотоод аюулгүй байдалд, ялангуяа нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх, эдийн засгийн тогтворгүй байдал үүсгэх, хууль сахиулах байгууллагыг хүчгүйдүүлэх, тогтворгүй байдал бий болгох ба түүнийг шийдвэрлэхдээ өөрсдийн ашиг сонирхол, бодлогыг суулгасан хууль батлуулах зэрэг арга байдаг байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах нь Үндэсний аюулгүй байдлын чухал нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Манай улсын хувьд эдийн засгийн хөгжил сул, улс төрийн байдал тогтворгүй, өргөн хэрэглээний бараа хоёр хөршөөсөө хараат, цөөн хүн амтай, газрын баялаг ихтэй өргөн уудам нутаг, хүн амын хэт төвлөрөл

¹ Цахим эх сурвалж, холбоос: www.wikipedia.org

² Ж.Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. - УБ., 2004.

³ С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. - УБ., 2007.

⁴ Ж.Бор, В. Чулуунбат. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. - УБ., 2012.

зэрэг нь гадны улс орнуудын анхаарал татсаар байгаа билээ.

Гэхдээ олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дан ганц цагдаагийн байгууллага хариуцан гүйцэтгэх нь учир дутагдалтай бөгөөд энэ чиг үүргийг гүйцэтгэхдээ төрийн нэгдсэн бодлого, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд¹, иргэд, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүд/субъектүүд/-ийн дэмжлэгтэйгээр хангагдах цогц асуудал болов уу гэж судлаач миний хувьд үзэж байна.

Улс орны нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал, улс төрийн нам, эвсэл, бүлгүүдийн үзэл бодлын зөрчил, алдаатай буруу шийдвэрээс үүдэлтэй нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болж энэ нь даамжирч онц байдлын хэмжээнд хүрч байсан баримт ч байна. Үүнийг нийгмийн шинжтэй гамшиг гэж томъёолжээ.

Нийгмийн шинжтэй гамшиг гэдэг нь нийгэмд аюултай үйл явдлын уршгаар тодорхой нутаг дэвсгэрт олон хүний амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа байгаль орчинд тодорхой хэмжээний материаллаг ба материал бус хохирол учирсан, хүмүүсийн амьдралын хэвийн үйл ажиллагааны нөхцөл алдагдсан эсвэл дээрхи хор уршиг үүсч болох хэмжээнд хүртлээ нөхцөл байдал хүндэрсэн байхыг ойлгодог байна².

Улс орны дотоод аюулгүй байдлыг хангах, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх, шинээр байгуулагдсан Цагдаагийн байгууллагын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чадавхийг сайжруулж, бэхжүүлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үр дүнгээ өгнө гэж үзэж байна. Үүнд:

- > Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрдэмтэн, судлаачдын бүтээл, ном, сурах бичиг ховор байгаа тул энэ чиглэлээр анхаарч ажиллах, хөгжүүлэх;

- > Улсын онц чухал объект болон дипломат байгууллагын аюулгүй байдлыг хангах, терроризмтой тэмцэх арга, ажиллагаа Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар³ нууцын зэрэглэлд хамаардагаас энэ төрлийн судалгаа, шинжилгээний ажил орхигдож, шинжлэх ухааны үндэстэй судалгаанд суурилсан шинэ бүтээлүүд төдийлэн гараагүй байна.

Ийм ч учраас эрдэмтэн, судлаачдыг энэ чиглэлээр судалгааны ажил хийлгэж, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, шинэ санал, санаачлага дэвшүүлэх, мэргэжлийн болон холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх;

- > Учирч болзошгүй аюул заналын хэмжээ, цар хүрээг макро, микро

¹ Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасныг ойлгоно.

² Б.Одбаатар. “Нийгмийн шинжтэй гамшигт байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зарим асуудал”. Хууль сахиулахуйн удирдлага сэтгүүл. - УБ., 2014. №1,2 (01).

³ Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль. Цахим эх сурвалж, холбоос:

www.legalinfo.mn

түвшинд тодорхойлж "Олон нийтийн аюулгүй байдлыг хангах бодлогын баримт бичиг" боловсруулан баталж. мөрдүүлэх;

> Хүний нөөцөө сургаж, бэлтгэх, мэргэшсэн чадварлаг нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

> Онц чухал объектуудын¹ хамгаалалтад инновацийг нэвтрүүлж, гадаад орнуудад ашиглагдаж байгаа арга, сүүлийн үеийн шинэлэг дэвшилтэд техник, технологийг ашиглах асуудлыг удирдлагын зүгээс менежментийн ухаанд тулгуурлан хөгжүүлэх;

> Онц чухал объектын хамгаалалт болон нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулахад Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуй нэгжүүд /субъектүүд/-ийн дэмжлэгийг авах, харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах үйл ажиллагааг шинэ шатанд гаргаж хөгжүүлэх, түүний эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг болно.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
цагдаагийн хошууч Ш.Даваа-Эрдэнэ*

ШИНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Цагдаагийн байгууллагаас гаргадаг гэмт хэргийн гаралт, түүнд дүн шинжилгээ хийсэн жил бүрийн тайлан, мэдээнээс дүгнэхэд сүүлийн жилүүдэд гэмт хэргийн гаралт байнга өсөн нэмэгдэж байгаагын зэрэгцээ түүн дотор эзлэх хүнд, онц хүнд гэмт хэргийн тоо буурахгүй байна.

Нөгөө талаар шинэ төрлийн гэх гэмт хэргүүд тухайлбал, хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хууль бусаар олж авах, борлуулах, тээвэрлэх, мөнгө угаах, мэдээлэл, технологийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд зохион байгуулалтын нарийн арга хэлбэрт шилжиж Монгол Улсын төдийгүй бусад улс орныг хамарсан гэмт бүлэглэлийн сүлжээнд хүртлээ тархсан байгаа нь сэтгэл түгшээж нийгэм, иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөлд нөлөөлөн сэтгэл түгшээж байна.

Шинэ төрлийн гэх дээрхи гэмт хэргүүд нь шинж байдлын хувьд урьд өмнө үйлдэгдэж байсан гэмт хэргүүдээс цоо шинэ арга, хэлбэрээр илэрч хүн

¹ Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын хамгаалалтад байх объектын жагсаалт”-д хамаарах объектууд.

төрөлхтөн, дэлхий нийтэд нэн аюултай гэмт хэрэгт тооцогдох болж өнөө үед нийгмийн хор аюул нь улам бүр ихсэж байна.

Орчин үед гэмт хэрэгтнүүд шинжлэх ухаан, техник технологийн дэвшилтэт аргыг ашиглан гэмт хэрэг үйлдэх болсон нь цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэхэд мэргэшлийн өндөр ур чадвар шаардаж эрс шинэчлэлт өөрчлөлт хийх цаг болсныг ч харуулж байна.

Нөгөө талаар гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгаж тогтоох уламжлалт арга, тактик өнөөгийн шаардлагад нийцэхгүй цаашлаад хуучин арга барилаар тэмцэх боломжгүй болж, харин уг ажиллагаанд бусад өндөр хөгжилтэй орны туршлагыг өөрийн орны онцлог нөхцөл байдалд тохируулан нэвтрүүлэх, шинжлэх ухаан, техникийн үсрэнгүй хөгжлийн ололт амжилтыг ашиглах явдал зүй ёсоор шаардагдаж байна.

Шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч арга барил, сэтгэлгээ нь нөгөө л хуучин хэвээрээ байсаар л байна.

Иймд шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэ төвшинд гаргах, гэмт хэрэг илрүүлэхэд орчин үеийн техник хэрэгсэл, шинжлэх ухааны ололт дэвшлийг ашиглах, бусад улс орны цагдаагийн байгууллагад алба хаагчдыг сургаж мэргэшүүлэх, туршлагыг судалж удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч байгаа юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.4.4 дэх хэсэгт "Монгол Улсын иргэнийг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс хамгаалах орчин, нөхцлийг сайжруулна¹" гэж заасан байдаг.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар Тагнуулын байгууллага Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 20 төрлийн; Авлигатай тэмцэх газар 8 төрлийн; Цагдаагийн байгууллага Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 182 төрлийн гэмт хэрэгтэй тус тус тэмцэх чиг үүрэгтэй байна. Цагдаагийн байгууллагын харьяаллын 182 төрлийн гэмт хэргээс 30 гаруй нь хар тамхи, хүний наймаа, мөнгө угаах зэрэг үндэстэн дамнасан шинжтэй, зохион байгуулалттай, гол төлөв нууц далд аргаар үйлдэгддэг манай улсын хувьд шинэ төрлийн гэмт хэргүүд эзэлж байна.

Шинэ төрлийн гэмт хэрэг гэдэгт Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуульд шинээр гэмт хэрэгт тооцогдохоор тусгагдсан гэмт хэргүүд, Эрүүгийн хуульд урьд гэмт хэрэг гэж тооцогдсон, шинэ төрлийн аргаар үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд, Монгол Улсын эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж заагаагүй боловч

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.nsc.gov.mn>